

Манмин Мэдээ

№ 64 2018 оны 9 сарын 23

Бурханы хайр ба эрх мэдэлт хүчээр дүүрэн ерөөлт цаг

Гадаадын 25 орон оролцсон '2018 Манмин бүх итгэгчдийн зуны цуглаан'



2018 оны 8-р сарын 6-8 нийг хүртэл 3н өдрийн турш Мүжү Догю сан амралтын газарт '2018 Манмины бүх итгэгчдийн зуны цуглаан' ивээл дүүрэн, аз жаргалтай болж өнгөрлөө. Гадаадын 25 орноос Эзэний боол пасторууд, болон итгэгч нар оролцсон энэ удаагийн зуны цуглаан нь GCN (Жи Си Эн) телевизээр шууд дамжуулагдан, англи, хятад, япон, орос, испани, франц, тайланд, герман, монгол, вьетнам зэрэг нийт 10н орны хэлээр шууд орчуулагдан нэвтрүүлэгдсэн юм. Мөн гадаадаас хэл ба сонсголын бэрхшээлтэй итгэгч нарын төлөө 8н (Солонгос, англи, малайз, тайланд, латви, дани, герман, хятад) орны дохионы хэлээр шууд дамжуулагдсан юм.

Энэ жил ч мөн урьдын адил сононууд итгэгч нарын гар хуруу, болон биен дээр халуун дотноор бууж ирэн сууж, Солонгос бүх орон нутгаар цаг агаарын байдал хэт халсан нөхцөлд ч зуны цуглаан болж буй Мүжү Догю сан амралтын газарт сэрүүн таатай салхи, зөөлөн бороо, ба үүлэрхэг байж

23-26 хэмийн дулаантай, хамгийн таатай гайхалтай цаг агаартай байлаа. Үүнд итгэгчид Гошен нутаг шиг үргэлж Бурханы орон зайд хамгаалагдсан хайр ба ивээлийг илүү гүнзгий мэдэрсэн цаг байлаа.

Сайны сэтгэл, итгэл, дуулгавартай байдал ба хариултын түлхүүр төрөл бүрийн эдгэрлийн хүч нөлөө илрэн гарсан "Сургаалийн цаг"

Зуны цуглааны эхний өдөр сургаалийн цагын номлогчоор И Сү жин пастор 'Сүнсний ертөнц' (Иохан 4:24) гэсэн сэдвээр сүнсний ертөнц бол сайн ба хайр, үнэнээр дүүрэн орон зай, болон Гурвын холбооны Бурхан зүрх сэтгэлдээ агуулсан зүйл нь бодитоор бий болох ертөнц юм гэж тайлбарлан, түүнчлэн сүнсний ертөнцийн үүд хаалгыг нээж, Бурханы хариулт ба ерөөлийг буулгах түлхүүр бол сайны сэтгэл, итгэл, Бурханы хүнийг хайрлан, түшиглэж, дуулгавартай дагах явдал юм гэж

онцолж байлаа.

Сургаалийн дараа И Сү жин пастор гэмшлийн магтаал, залбирлыг удирдаж, И Жей руг тэргүүн пасторын залбирал хийж өгсөн эрх мэдэлт хүчтэй гар алчуур (Үйлс 19:11-12)-аар индэр дээрээс нийт оролцогчид руу хандан залбирал хийж өгсөн юм. Үүнтэй хамт Манмин залбирлын хүрээлэнгийн ахлагч И Буг ним, Урлагын холбооны ерөнхий удирдагч И Хи жин пастор, Манмины бүх салбар сүмүүдийн ерөнхий удирдагч И Хи сон пастор, Африк дахь Манмин салбар сүмүүдийн ерөнхий удирдагч Жон Мёон ху пастор зэрэг пасторууд залбирал авахаар бүртгэгдсэн итгэгч нар дээр биечлэн залбирч өгсөн юм.

Залбирал дууссаны дараа итгэгч нар гэрчилж, уушгиний хорт хавдар, тархины үрэвсэлээс үүдсэн мэдрэлийн өвчин, атопи арьсны өвчин, арьсны үрэвсэлт өвчин, нуруу үе мөчний сүрьеэ өвчин, биеийн тал саажилт, ярианы бэрхшээл, шөрмөсний гэмтэл

зэрэг өвчнөөсөө эдгэрч, ганихрал зэрэг сэтгэцийн гаралтай бусад өвчнүүдээс эдгэрснээс гадна нүдний хараа, чихний сонсгол сайжирсан гэх мэтээр Бурхандаа агуу ихээр алдрыг өргөсөн цаг байлаа. Үүнээс гадна гадаадын 6н орноос ирж оролцсон 28н хэл, сонсголын бэрхшээлтэй итгэгч нарын 24 нь сонсдог болж, өмнөхөөсөө илүү сайн сонсдог болсон, ясны хорт хавдраар зовиурлаж байсан нэгэн хөгжлийн бэрхшээлтэй итгэгч Ариун Сүнсний галыг авч бүрэн эдгэрсэн гэж гэрчилцгээж байлаа.

Мөн дэлхий өнцөг булан бүрээс GCN (Жи Си Эн) телевизээр, интернетээр хамтдаа оролцсон итгэгч нар ч цаг орон зай үл хамааран Ариун Сүнсний хүч нөлөө илрэн гарсан юм. Юүтүбэ сувгаар Испаниас зуны цуглаанд оролцсон Ибэни Габриел итгэгч толгой эргэх болон толгой хүчтэй өвдөж, бөөлжих зэргээс эдгэрч, Энэтхэг Дели хотоос оролцсон итгэгч нар алхаж явдаг болж, бөөрний чулуу, төрөл бүрийн өвчнөөсөө эдгэрсэн гэж гэрчилж байлаа.

Ариун байдлын мэргэн ухаан

“Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж. Үр жимс нь зөв байгчийн үр нь амар тайвныг бүтээгчдээр амар тайванд таригддаг юм” (Иаков 3:17-18).



Манмин төв чуулганы тэргүүн пастор,
И Жей руг пастор

- Есүс Христийн нэгдсэн ариун урсгалын ерөнхий удирдагч
- Христийн сайн мэдээ сэргэлтийн холбооны ерөнхийлөгч
- Үндэсний хайрын залбирлын нэгдсэн хорооны хамтын удирдагч
- (GCN) (Жи Си Эн) Глобал Христийн телевизийн ерөнхий захирал
- (WCDN) Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбооны ерөнхий захирал
- (MIS) Манмин олон улсын библийн их сургуулийн захирал
- Нэгдсэн ариун библийн сургуулийн захирал
- Библи судлалын доктор, Теологийн хүндэт доктор
- Христийн телевиз, радиогийн албан ёсны сургаал заагч
- Чусон илбу, Жүнан илбу, Туна илбу, Хангүг илбу, Сөүл сонин Хангёорэ сонин, Кеонхян сонин, Хангүг кёнжэ сонин, Ши са ньюс, Кристиан сонин зэрэг өдөр тутмын сонин, сэтгүүлд итгэлийн амьдралын тухай байнгын нийтлэгч
- АНУ-н Нью-Йорк, Вашингтон, Балтимор, Мерилэнд, Лос-Анжелос, Хавай, Япон, Пакистан, Филиппин, Аргентин, Гондурас, Перу, ОХУ, Герман, Кени, Танзани, Уганда, Конго бүгд найрамдах улс, Израйль Иерусалим, Эстони зэрэг улс орнуудад нэгдсэн их цуглааныг удирдан явуулсан

Хүн болгон эрхэмлэн нандигнадаг зүйл байдаг. Олон хүмүүс эрүүл мэнд, эрх мэдэл, нэр хүнд, алдар гавьяа, мэдлэг боловсрол, мэргэн ухаан зэргийг эрхэмд тооцдог бол чухам хамгийн эрхэм нандин зүйл гэж юу вэ?

Амьдралын ухааныг бичиж үлдээсэн Сургаалт үгс номын 3:13-14д “Мэргэн ухааныг олдог хүн, ухаарал авдаг хүн ерөөлтэй еэ. Учир нь мэргэн ухааны ашиг болбоос цалин цагаан мөнгөний ашгаас ч илүү, Орлого нь шижир алтныхаас ч илүү” гэсэн бол 16-17р ишлэлд “Түүний баруун гарт нь урт удаан амьдрал залрах агаад зүүн гарт нь алдар суу болон баялаг буй. Мэргэн ухааны зам тааламжит бөгөөд бүх жим нь амар тайван” гэжээ. Тийм ч учир “Мэргэн ухааны эхлэл бол түүнийг олж авах” (Сургаалт үгс 4:7) гэсэн ба “Яагаад гэвэл Бурханы мунхаглал нь хүмүүсээс илүү хүчирхэг юм” (1 Коринт 1:25) гэж сургамжилсан байдаг.

Мөн 1 Коринт 3:18-20д “Хэн ч өөрийгөө бүү мэхлэг. Хэрэв та нарын дунд хэн нэг нь энэ үед өөрийгөө мэргэн хэмээн боддог бол тэр хүн мэргэн болохын тулд мунхаг болог. Учир нь энэ ертөнцийн мэргэн ухаан бол Бурханы өмнөх мунхаглал юм. Энэ нь Мэргэн хүмүүсийг Тэр башир байдлаар нь барьдаг гэж бичигджээ” гэсэн байдаг.

Энэ ертөнц нь хорон муу зальт санаа, төлөвлөгөөг мэргэн ухаан гэдэг хүмүүс байдаг ч эцэстээ тийм биш байдаг. Ийм мэргэн ухаан нь сайны Бурхан хамгаалж өгөх боломжгүй тул хэдийгээр их зүйл олж, амжилт яваа мэт боловч, хэзээ нэгэн цагт замхран алга болдог. Харин эсрэгээрээ сайн Бурханы мэргэн ухааныг авбал бүх зүйл амжилт олж, гэр бүл, ажлын талбар, сургууль, хамт олон зэрэг байгаа газар болгондоо хайрлагдан Бурхандаа алдрыг өргөх болдог.

1. ‘Дээрээс ирдэг мэргэн ухаан’ гэж юу вэ?

Иаков номын 3:17д “Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун,...” гэсэн ба үүнийг л ‘Дээрээс ирдэг мэргэн ухаан’ Бурханы мэргэн ухаан гэж байгаа юм. Сургаалт үгс номын 9:10д “Эзэнээс эмээхүй нь мэргэн ухааны эхлэл мөн. Ариун Нэгэнийг таньж мэдэх нь оюун ухаан мөн” гэсэн бол 16:6д “Үнэн ба хайр энэрэл нүглийг цагаатгадаг. Эзэнээс эмээхүй нь хорон муугаас холдуулна” гэжээ. Сайн Бурханыг хүндэтгэн, хорон муугийн алив хэлбэрийг хаяж, ариун байдлыг олно гэдэг нь Бурханы мэргэн ухааныг авах арга зам юм.

Сайн ба хайр, үнэний уг үндэс Есүс нь Бурханы мэргэн ухаанаар үгээ айлдаж, үйлдсэн юм. Лук номын 10-р бүлэгт үзвэл нэгэн хуулийн багш Есүсийг сорьж, яавал мөнх амийг авах вэ? гэж асуудаг. Тэгтэл Есүс “Хуульд юу гэж бичигдсэн байдаг билээ? Чи хэрхэн уншдаг вэ?” гэж хариу асуув. Үүнд тэрээр “Чи өөрийн Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч чадал, бүх оюун ухаанаараа хайрла, Мөн хөршөө өөрийн адил хайрла” гэдэг гэж хариулав. Есүс хариуд нь “Чи зөв хариуллаа. Үүнийгээ үйлд, тэгвэл чи амьдарна” гэж хариулж өгсөн юм.

Есүсийг сорих гэсэн түүний оролдлого санаанд нь хүрээгүй тул тэрээр дахин “Миний хөрш гэдэг чинь хэн бэ?” асуулаа. Есүс түүний сэтгэлд хайр байхгүйг хэдийн мэдэж байгаа ч түүнийг сэтгэлийг тавгүйтүүлэлгүй ухааруулах гэж сайхан сэтгэлтэй Самари хүн зүйрлэлийг тайлбарлаж өгсөн юм. “Нэгэн хүн замд явж байгаад дээрэмчидтэй тааралдаж, бараг үхэх гээд замд хэвтэж байхад нэгэн тахилч түүнийг хараад зүгээр өнгөрөөд явав. Леви хүн ч мөн л хажуугаар нь өнгөрч явсан ч нэгэн Самари хүн түүнийг хараад ихэд өрөвдөж, түүнд тусалж халамжилсан бол чинийхээр хэн түүний хөрш вэ?” гэв.

Тухайн үед Самари нутгийн хүн харь үндэстнүүдтэй цус холилдсон гэх шалтгаанаар Иудейчүүд их гадуурхдаг байсан юм. Тэр хуулийн багш Есүст хандан яах ч аргагүй “Өршөөл энэрэл үзүүлсэн нь” гэж хариулав. Тэгэхэд Есүс “Чи ч гэсэн түүнчлэн үйлд” гэж айлдсан юм. Есүс хуулийн багшийг хөршөө хайрладаггүй гэж шууд зэмлээгүй ч хангалттай ойлгогдохоор зүйрлэлээр ухааруулж өгсөн юм.

Сэтгэлдээ сайны шинж дутуу хүн бол Есүстэй ижил байдалд орвол бусдыг хатгах, эвгүй байдалд оруулах гэдэг. Шууд хатгахгүй ч бусдад хорон байдлаар хариу барих, үг хэлээр давах гэдэг. Гэвч Есүс шиг сайны мэргэн ухаантай хүн бусдыг үл тоох, эсвэл сэтгэлийг тавгүйтүүлэлгүй ухааруулж тайлбарладаг. Энэ л Бурханы өгдөг мэргэн ухаан ба сайны ухаан юм.

2. Ариун зүрх сэтгэлээс гарах сайны мэргэн ухаан

Бурхан бол гэрэл бөгөөд сайны уг үндэс юм. Тийм болохоор бид хорон мууг хаяж, гэрэл дотор үйлдэн, ариун байдал руу орох тусам Ариун Сүнсний удирдамжыг авч тэнгэрээс мэргэн ухааныг авах боломжтой. Бурханы мэргэн ухааныг авна гэдэг нь Ариун Сүнсний дууг сонсч, удирдуулна гэдэгтэй утга ижил юм. Зүрх сэтгэлд хорон муу байхгүй байх нь ариун байдлыг суурь нөхцөл ба ариухан мэргэн ухааныг авах үед ч сэтгэлдээ сайны шинж байх тусам илүү нарийн тодорхой удирдуулах боломжтой.

Энэ мэт Бурханы мэргэн ухаан нь үргэлж сайн цайлган арга ухаанаар хэрэгждэг. Зүрх сэтгэлд хорон муу байвал хэн нэгэн сайны мэргэн ухааныг зааж өгсөн ч түүнчлэн хэрэгжүүлэхэд хэцүү байдаг. Эхлээд зүрх сэтгэл дэх хорон мууг хаях нь мэргэн ухааныг өгөгдөх, ба хүлээн авахад дөт зам болдог.

Зүрхэндээ хорон муугүй хүнтэй ярилцахад л бусдын сэтгэлийг мэдэрч, сайн сайхан хандлагаар өөдрөг ивээлтэй үг, хэний ч сонссон эелдэг амгалан үгүүд гардаг. Залбирахдаа ч Бурханы сэтгэлийг өвтгөх хэмжээний илэрхийлэл бус цайлган залбирал хийдэг байна.

Гэтэл сайн цайлган, ивээлтэй үгс, цайлган залбирал нь өөрөө хичээгээд гаргадаг зүйл биш юм. Зүрх сэтгэлд хорон муу байвал санамсаргүйгээр тэр нь гарч ирдэг. Эсрэгээр нь зүрх сэтгэл цайлган бол аядаа сайны залбирал, ивээлтэй өөдрөг үгс гардаг.


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг
Утас: 88107327, 91170773, 89737773

www.manmin.org
www.gcntv.org

Энэ дэлхийд амьдрах явцад өөрийн хийгээгүй үг ба үйлдлээсээ болж эргэн тойрондоо буруу ойлголт төрүүлж болох юм. Уг нь сайны үүднээс хэлтэл харин ч бүр өөрийгөө эвгүй байдалд оруулах юм уу олны шүүмжлэлд өртөгдөх тохиолдол байдаг. Энэ нь гомдоллон, зөв бурууг ялган маргахаас илүү Бурханд даатган Түүний нөлөөлөхийг хүлээх нь дээр байдаг. Учир нь өөрийгөө өмгөөлөх тусам буруу ойлголт л хураагддаг болохоор.

Мөн маргалдаж, өөрийнхөө буруугүй байдлаа илчиллээ гэхэд тэр явцад бусдын алдаа дутагдлыг ил гаргах ч болдог. Хэдийгээр тэгээгүй ч гэсэн бие биетэйгээ харьцах харилцаа тавгүй болдог. Эсрэг талын хүн өөрийн алдаа дутагдал ил гарах үед илүү их тавгүйтлийг өвлөдөг.

Тиймээс 2 Тимот 2:23 “Харин мунхаг, эелдэг бус маргаанууд нь тэмцэл мөргөлдөөн бий болгогчийг мэдэх тул тэдгээрээс татгалз” гэсэн байдаг. Маргалдахад харьцаа муудаж, эв нэгдэл хагарч, бие бие рүүгээ нуруугаа харуулах болдог. Үнэхээр ухаалаг, цайлган хүн бол маргалддаггүй. Түүний оронд чимээгүйхэн эсрэг талынхаа хүнийг өвлөхөд үнэн байдал илрэн гарч аяндаа буруу ойлголт тайлагдах нь дээр байдаг. Үнэн байдал илчлэгдэх үед эсрэг талын хүний сэтгэл уярч, илүү гүн харьцаа тогтоодог.

Магадгүй төсөөлж ч чадаагүй хүнд явдал тохиолдоход Ариун Сүнсний тусламжтайгаар залбирахад эсрэгээрээ ерөөлийн боломж болгож хувирч болох юм (Сургаалт үгс 3:6). Чимээгүйхэн Бурханы хүслийг ухаарах гэж хичээх тусам өөрийн алдааг ухаарч, өөрчлөгдөх боломж олж, хилс гүтгэгдсэн ч Бурхан бүгдийг мэдэж байгаа тул цаг нь ирвэл Өөрөө буцаан төлдөг учраас юм. Энэ л дээрээс ирэх ариун мэргэн ухаан юм.

3. Сайн байхгүй мэргэн ухаан нь хоосон юм
 Ердийн үед бусдыг харж ханддаггүй хүн, өөрийн үүднээс л бодож, гоморхож, тавгүйдэг Бурханд бас тэгж ханддаг. Сайны болон сэтгэл хөдлөм залбирах ёстойг мэдэж байсан ч хорон муу байвал залбиралд нь холилдсон байдагыг харж болно.

Сэтгэлдээ тавгүйтэл байвал “Цайлган залбираарай” мэргэн ухааны сургаалийг сонссон ч түүнийг хэрэгжүүлж чаддаггүй. “Бүх зүйлд талархалаа илэрхийл” гэсэн ч сэтгэлд нь гоморхол дүүрэн байгаа тул талархалын залбирал гардаггүй. Түүнчлэн миний залбирал ер нь Бурханыг баярлуулах хэмжээний залбирал уу эсвэл Бурханы сэтгэл өвдөм хариулт авч чадахгүй залбирал уу гэдгээ эргэж харах хэрэгтэй юм. Бурхан бол зөвт хүний цайлган залбиралд баярлан маш хурдан хариулж өгдөг (Иаков 5:16).

Давидын хүү Абсаломын гадна төрх байдлаар онцгой гойд (2 Самуел 14:25) мөн ухаалаг байсан ч зүрх хорон муу тул өөрийн ухааныг хорон муугаар хэрэглэдэг. Абсаломын эх ондоо том ах Амнон нь өөрийн охин дүү Тамарийг ашигласанд тэрээр их уурлаж байлаа. Тэгж байгаад аав Давид Амнонд ямар ч шийтгэл зэмлэл өгөөгүйд бүр тавгүйтэж байлаа. Тэрээр өөрийн ийм байдлаа ил гаргах таатай боломжыг хүлээж байсан ба 2 жилийн дараа Абсалом хонины ноос хяргах ёслолд Амноныг урьсаны дараа зарц нартаа тушаан түүнийг хороосон юм. Тэгээд тэрээр Давидаас зугтан хол амьдрах болсон юм.

Цаг хугацаа өнгөрч энэ байдлаас болж гуниглаж байгаа Давидын сэтгэлийг мэдсэн Иоб цэргийн жанжин Абсаломыг хайж олон Иерусалимд авчирдаг ч Давид үүнээс 2 жил болоход түүнтэй уулзаагүй юм. Үүнд өөрийгөө аавдаа шоовдорлогдсон гэж үзээд өс санаж

тэрсэлдэхэд бэлдэж эхлэв.
 Өөртөө хүмүүсийн сэтгэлийг урвуулах гэж Давид хаан ард түмнээ хайрлахгүй байна би хайрлах болно намайг дага гэх мэтээр өөрийн хүмүүсийг цуглуулж, цэрэг зэвсэг бэлдэж байв (2 Самуел 15:2-6).

Эцэст нь Абсалом тогтсон цагтаа бослого гаргаж, Давид сандарч тэвдэн хурдан зугтаах байдалд хүрсэн юм. Абсалом нь Давидын шадар зөвлөх Ахитофелийг хүртэл өөрийн талд урвуулсан байдаг. Ахитофел нь хичнээн авхаалжтай маш чадварлаг мэргэн зөвлөх байсан ба түүний зөвлөгөө нь жирийн хүн мөртлөө Бурханы үгтэй адил мэт тооцогддог байлаа гэсэн байдаг (2 Самуел 16:23).

Гэсэн ч Абсаломын бослого удалгүй амжилтгүй болдог. Бурхан түүний мэргэн ухааныг харанхуй болгосон юм. Ахитофел Давидыг нэг мөсөн дарж авах талаар төлөвлөж байсан ч Абсалом нь Давидад ашигтай төлөвлөгөөг бий болгосон хүний үгийг сонссон юм. Хэдийгээр Абсалом ухаалаг ч түүний дүгнэх, шийдвэр гаргах чадварыг Бурхан бүрхэг болгосноор өөрөө сүйрлийн замыг сонгосон юм. Энэ мэтчилэн хичнээн ухаалаг байсан ч дээрээс ирэх Бурханы ариун мэргэн ухаан л биш бол усны хөөс шиг хоосон болохыг ухаарах хэрэгтэй юм.

Хайрт итгэгч та бүхэн, Бурхан мэргэн ухаан нь хүнийхээс агуу бөгөөд дэлхийн мэргэн ухаанаас өөр юм. Сайны аргаар хэрэгждэг тул тэр ухааныг ухаарахын тулд ухаараад үйлдэхийн тулд эхлээд зүрх сэтгэлийн ариун байдлыг олох хэрэгтэй юм. Мэргэн ухааны эхлэл болсон Бурханаас ариун мэргэн ухааныг гуйж бүх зүйлдээ амжилттай арвин дүүрэн үр жимсээр алдрыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Үүлээр халхалж, сэрүүхэн салхи таатай цаг агаарт болсон Спортын тэмцээн



Зуны цуглааны 2-р дахь өдөр үдээс өмнө спортын тэмцээн дэлгэцээр дамжуулан И Жей руг тэргүүн пасторын залбирал аван эхлэсэн юм. 1-р их бүлгийн баг (Хятадын хэсэг•Гадаад итгэгчдийн хэсэг нийлсэн), 2-р их бүлгийн баг, 3-р их бүлгийн баг (Орон нутгийн болон гадаадын салбар цуглаан болон гадаадаас ирсэн итгэгчид хамарсан) олс таталт, бөмбөлөгтэй буухиа, 100м ойрын зайн гүйлт, холын зайн гүйлт, гар барилдаан, буухиа гүйлт гэх мэт бусад төрлөөр нийт 18н алтан медалийн төлөө сайны өрсөлдөн тэмцсэн юм. Энэ жилийн тэргүүн байрын шагналыг 3-р их бүлгийн баг шалгарсан бол эрэгтэй эмэгтэй шилдэг тамирчнаар холын зайд тус тус алтан медаль хүртсэн 3-р их бүлгийн И Хун гүг итгэгч ба И Жэ а эгч дүү шалгарсан юм.

Солонгосын орон нутаг даяар хэт халсан цаг агаарт ч энэхүү спорт тэмцээнд Бурхан хурц нарыг үүлээр халхлан өгч, сэрүүхэн цэнгэг салхиар үргэлжлүүлэн үлээж өгсөн гайхамшигт цаг агаар байсан ба +26 хэмийн дулаантай байсан юм. Түүнчлэн “Манмин” гэх нэрийн дор нэг гэр бүл болон Эзэн дотор хайраар нэгдэн эв нэгдэл дотор спортын тэмцээн явагдаж, нийт оролцогчдын дунд азын сугалааны цаг ч болж өнгөсөн юм.

2018
Манмин зуны цуглааны спортын тэмцээн



Өөрчлөгдсөн итгэгч нарын Бурхандаа өргөх хайр ба талархалын үнэр “Магтаал ба галын наадам”

Хоёр дахь өдрийн орой магтаал ба галын наадмыг уг зуны цуглааны номлогч И Сү жин пасторын удирдлагаар төв сүмийн урлагын нэгдсэн баг, Нисси

оркестр, Алтан бүрээ ансамбли, Power worship, Глори вошип, Гэрлийн дуу, Кристалл зэрэг багууд хамтдаа сэтгэл хөдлөм магтаалын цаг байлаа.

Эхний хэсэгт итгэгчид хоосон бус бодит зүйлсрүү тэмүүлж, ерөөлт амьдралаар амьдрахын турш өөрчлөж өгсөн Ариун Гурвал Бурханы агуу ивээл ба хайранд талархал илэрхийлэн

одоо тэр хайраар ариун сайн мэдээ хоньчины эрх мэдэлт хүчийг бүх дэлхийд дамжуулах хүсэл төлөвлөгөөг шингээн гал халуунаар магтаагсаан юм.

Үргэлжлүүлэн төрөл бүрийн гоёмсог өнгө гэрэл бүхий салютын үзүүлбэр, 2-р хэсэгт Бурхан Аавын бэлтгэж тавьсан үзэсгэлэнтэй тэнгэрийн орон Шинэ Иерусалимын эзэд болон

“Мөнхийн газар” “Үзэсгэлэнтэй Шинэ Иерусалим”, “JESUS”, “Их Эзэнийхээ бүтээсэн”, “Хайртай Манмины итгэгч нараа” зэрэг магтаалыг бүх сэтгэлээр магтаж, Эзэний өгсөн хүч чадлаар Бурхан Аавын бэлдэж өгсөн Шинэ Иерусалим хүртэл зорьсон хүрэх хүртэл эрч хүчтэйгээр давшин урагшилж байгаа тухай магтаалаар илэрхийлсэн юм.



УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин МЭДЭЭ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дигитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminnews@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин